



JICA ALUMNI MONGOLIA

ЖАЙКА-ын Сургалт Төгсөгчдийн Холбоо

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, Бодь цамхаг, 7-р давхар, ЖАЙКА-ын Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Утас: 325 939, 311 329 И-мэйл: jicamg-alumni@jica.go.jp

Цахим хаягууд: www.jaam.mn, <https://www.facebook.com/JICA Alumni Association Mongolia>

ЭНЭ ДУГААРТ

1. Хүүхдийн хөгжилд томчуудын хандлага нэн чухал	1
2. ЖАЙКА болон Боловсон хүчний чадавхыг хөгжүүлэх үйл ажиллагааны тухай.....	2
3. Мэдлэг хамтран бүтээх хөтөлбөрт бага, дунд боловсролын байгалийн ухааны салбарын багш нар хамрагдана.	2
4. Бүгд Найрамдах Ардчилсан Конго Улсад ЖАЙКА-ын Олон Улсын Гамшгаас Хамгаалах Тусламжийн анги ажиллаж байна.	3
5. Хагас зуун жил үргэлжилж байгаа Япон болон Бразилийн хамтын ажиллагаа улам өргөжсөөр.....	3
6. Өмнөд Суданы анхны олимпын тамирчдыг ЖАЙКА дэмжинэ.....	4
7. “Follow up” сургалт семинарын төслийн шалгаруулалтын дүн гарлаа.	5
8. Японы хөгжлийн туршлагаас	7
9. Хүнсний аюулгүй байдал гэж юу вэ?	8

ХҮҮХДИЙН ХӨГЖИЛД ТОМЧУУДЫН ХАНДЛАГА НЭН ЧУХАЛ

2015 онд Савада Асүка нь Дорнод аймгийн 1-р сургуульд тусгай хэрэгцээт боловсролын багшаар томилогдон иржээ. Тус сургууль нь аймагтаа цорын ганц хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургах ангитай бөгөөд одоогийн байдлаар 15 хүүхэд суралцдаг.

Савада сайн дурын гишүүн тус ангийн 5 хүүхдэд аяга таваг угаах, цэвэрлэгээ хийх зэрэг өдөр тутмын амьдралд шаардлагатай зүйлийг зааснаар, хүүхдийн өөрөө бие даан хийж чадах зүйлс нэмэгдсээр байна. Мөн зарим нэг хүүхдэд ганцаарчилсан сургалтыг бас явуулж байгаа.

Гэвч яг одоогийн ерөнхий боловсролын сургалтын аргаар хүүхдүүдийг сургахад бэрхшээлтэй талууд нилээн их байгаа төдийгүй, эцэг эхчүүд болон эргэн тойрны томчуудын хандлагыг өөрчлөхгүйгээр, хүүхдийг нээж, хөгжүүлэхэд асуудалтай юм.



Тийм учраас цаашид хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг хөгжүүлэхэд сургуулийн хамт олон болон эцэг эхчүүдийг оролцоог нэмэгдүүлж,

тэдэнтэй хамтдаа тусгай хэрэгцээт боловсролын орчинг сайжруулах зорилготой байна.

ЖАЙКА БОЛОН БОЛОВСОН ХҮЧНИЙ ЧАДАВХЫГ ХӨГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

1974 онд анх байгуулагдсан цагаасаа хойш ЖАЙКА-ын үйл ажиллагааны гол үзэл санаа нь аливаа улсын нийгэм эдийн засгийн хөгжлийн гол цөм нь “чадавхыг хөгжүүлэх” явдал байна гэдэг үзэл байсаар ирсэн бөгөөд мэргэжилтнүүдийг томилох, хөгжлийн төслүүд, хөгжлийн судалгааны төслүүд, сургалтын хөтөлбөрүүд гэх мэт тодорхой арга хэмжээнүүд хэрэгжүүлсээр ирвэ.

Энэхүү олон төрлийн хөтөлбөрийн дунд Сургалтын хөтөлбөрүүд нь ЖАЙКА-ын үйл ажиллагааны нэгэн чухал хэсэг болж ирсэн билээ.

Японд болдог сургалтуудаараа түншлэгч улсууддаа Японы нийгэмд бий болж хуримтлагдсан туршлага арга барилыг олж авах боломжийг олгодог. Түншлэгч орнуудаас ирсэн оролцогчид нь өөрсдийн чадавхыг болон өөрсдийн байгууллага улс орны чадавхыг дээшлүүлэхэд зориулан шинэ мэдлэг мэдээлэл олж авах, өөрсдийн мэдлэгийг дахин шинээр бий болгох боломжтой болдог.

Өнөөг хүртэл хэрэгжүүлсэн 460 орчим сургалтаар маш олон талын мэргэжлийн салбарыг хамарсан бөгөөд тухайлбал үүнд боловсрол, эрүүл

мэнд, дэд бүтэц, эрчим хүч, худалдаа, санхүү, хөдөө аж ахуй, хөдөөгийн хөгжил, хүйсийн тэгш байдал, байгаль орчны хамгаалал зэрэг багтаж байна. Олон төрлийн хөтөлбөрүүд зорилтог байгууллагынхаа онцлог хэрэгцээнд чиглэсэн байдлаар хэрэгждэг бөгөөд эдгээрт бодлого боловсруулагч байгууллага, үйлчилгээний байгууллага, судалгааны болон боловсролын институцүүд зэрэг багтаж байна. Зарим хөтөлбөрүүд нь хөгжлийнхөө явцад ижил төстэй асуудлуудтай тулгарч буй хэсэг бүлэг улсад чиглэсэн байдаг.

МЭДЛЭГ ХАМТРАН БҮТЭЭХ ХӨТӨЛБӨРТ БАГА, ДУНД БОЛОВСРОЛЫН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАРЫН БАГШ НАР ХАМРАГДАНА



Уг “Мэдлэг хамтран бүтээх хөтөлбөр (Залуу удирдагчид)”-ийг ЖАЙКА (Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага) хөгжиж буй орнуудын хүний нөөцийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Япон улсын Засгийн газрын Техникийн туслалцааны хамтын ажиллагааны хүрээнд хэрэгжүүлж байна.

2015 оны 2-р сард Японы Засгийн газрын танхимаас гаргасан “Хөгжлийн хамтын ажиллагааны дүрэм”-д дараах зүйлийг тодорхой тусгагдсан байна. Үүнд: “Япон улс нь хөгжлийн хамтын ажиллагаандаа, тухайн улсынхаа тусгаар тогтнол, хүсэл зорилго, улс орны онцлогийг нь хүндэтгэн үзэж, тухайлбал харилцан санал солилцох, хамтран ажиллах замаар талбар дээрх

хэрэгцээнд нийцүүлэн, хамтрагч орнууддаа тохирсон хэлбэрээр аливаа зүйлийг хамтдаа бүтээх үзэл санааг хэрэгжүүлж ирсэн билээ. Япон улс нь мөн хөгжиж буй орнуудтай харилцан нэгнээсээ суралцаж, хамтдаа төлөвшин хөгжсөнөөр хоёр талт харилцан ашигтай харилцааг хөгжүүлж ирсэн ажээ.”

Тус хөтөлбөрийн хүрээнд ирээдүйд улс орныхоо манлайлагчид болох залуу удирдагчид Япон улсад 2016 оны 11 сард 19 хоногийн хугацаатайгаар очин сургалтанд хамрагдах юм.

Сургалтанд хамрагдсанаар оролцогчид Японы бага, дунд боловсрол болон байгалийн ухаан ба математикийн боловсролын агуулга зорилго, багш нарын сургалтын хөтөлбөр болон түүний агуулга, сургуулийн боловсролын агуулга онцлогын талаар цогц ойлголт авах юм.

Энэхүү “Мэдлэг хамтран бүтээх хөтөлбөр” нь хамтдаа суралцах процессийн гол цөм нь болно гэдэгт бид итгэж байна.

БҮГД НАЙРАМДАХ АРДЧИЛСАН КОНГО УЛСАД ЖАЙКА-ЫН ОЛОН УЛСЫН ГАМШГААС ХАМГААЛАХ ТУСЛАМЖИЙН АНГИ АЖИЛЛАЖ БАЙНА



Японы Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага ЖАЙКА-ын Олон Улсын Гамшгаас Хамгаалах Тусламжийн Анги (JDR)-ийн Халдвар өвчний судалгааны багынхан 7 сарын 20-ны өдөр, Бүгд Найрамдах Ардчилсан Конго улсад тархаад буй Шар чичрэг (халуун орны халууран

дамждаг) халдварт өвчнийг намжаахад туслах зорилгоор очжээ.

Тус халдварт өвчний судалгааны баг нь дэлхийд нийтэд томоохон асуудал болоод буй халдварт өвчний тархалтын эсрэг ажилладаг ба, Япон улсын Гадаад харилцааны мэргэжилтэн, ЖАЙКА-

ын ажилтан, халдварт өвчин судлаач зэрэг чадварлаг мэргэжилтэнгүүдээс бүрддэг ажээ.

2015 оны 12 дугаар сараас эхлэн, Ангол, Уганда, Конго улсад Шар чичрэг өвчин дэлгэржээ. Тус улсын 5 том мужид 1900 гаруй хүн тус өвчнөөр өвчилснөөс одоогийн байдлаар 95 хүн нас барсан байна.

Шар чичрэг өвчин нь шумуулаар дамжин халдварладаг. Өвчний нууц үе нь 3-6 хоног ба халуурах, толгой өвдөх шинж тэмдэг илэрдэг байна. Эмчилгээний эм байхгүй бөгөөд зөвхөн вакцинаар хамгаалах боломжтой.

Одоо тус улсад Дэлхийн Эрүүл Мэндийн Байгууллага, Америкийн халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх төв зэрэг олон байгууллагууд очин, тусламжийн үйл ажиллагаагаа явуулж байна. Японы Халдварт өвчний судалгааны багынхан ч эдгээр гадны байгууллагуудтай хамтран ажиллахын сацуу өөрсдийн туршлага дээр үндэслэсэн аргуудыг ч бас хэрэглэж байна.

ХАГАС ЗУУН ЖИЛ ҮРГЭЛЖИЛЖ БАЙГАА ЯПОН БОЛОН БРАЗИЛИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА УЛАМ ӨРГӨЖСӨӨР

7 сарын 15-ны өдрийг Нэгдсэн Үндэстний Байгууллагаас “Дэлхийн Залуучуудын технологийн өдөр” болгон зарлажээ. Дэлхийн олон оронд залуучуудын ажилгүйдлийн байдал хурцадмал байгаа өнөө үед, залуучууд шинэ техник, технологийн чиглэлээр түлхүү суралцаж, түүнийгээ үйлдвэрлэлд нэвтрүүлснээр ажлын байр илүү нэмэгдэх юм.

Үүнтэй холбогдуулан ЖАЙКА нь Бразилийн мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвтэй хамтран шинээр 2 төсөл хэрэгжүүлэхээр болжээ. Уг төсөлд Бразилийн хөрш орон Парагвай улс, Африкийн Ангол улсын мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв ч мөн хамтран оролцох юм.

Бразилийн Үндэсний Аж Үйлдвэр, Мэргэжлийн Сургалт Үйлдвэрлэлийн төв (SENAI) нь 1942 онд байгуулагдсан бөгөөд орон даяар 900 гаруй сургалт үйлдвэрлэлийн баазтай, нийтдээ 27 сая гаруй хүн тус төвөөр дадлагдажсан байна.



Япон улс 1962 оноос тус төвийн үйл ажиллагааг дэмжин, өөрсдийн мэргэжилтнүүдээ илгээсэн ба 2000 оноос хойш ЖАЙКА тус төвтэй хамтран Өмнөд Америкийн бүс нутаг болон Африкийн нэгдсэн улстай хамтран 3 талт хамтын ажиллагаа явуулахаар болжээ.



Энэ хүрээнд Парагвай улсад 6 сараас эхлэн 4 жилийн хугацаатай “Аж үйлдвэрийн салбарт шаардлагатай боловсон хүчнийг бэлтгэх” төсөл хэрэгжиж байна. Төслийн багт Японы мэргэжилтэнгүүдээс гадна Бразилийн үндэсний аж үйлдвэр, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн мэргэжилтнүүд багтан, хамтран аж үйлдвэрийн менежментийн чиглэлээр шинэ төлөвлөгөөг боловсруулж, мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн багш нарын заах аргыг сайжруулах чиглэлээр ажиллаж байна.



Ангол улсад ч үүнтэй адил “Виана (Viana) Сургалт Үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааг бэхжүүлэх” төсөл удахгүй хэрэгжиж эхлэх гэж байна. Тус улс дотоодын мөргөлдөөний улмаас олон байшин барилга үгүй болсон тул, барилгыг дахин сэргээх, барих асуудал нэн шаардлагатай ба энэ салбарын мэргэжилтэнгүүд ч дутагдалтай байгаа. Мөн Ангол болон Бразил улсын албан ёсны хэл нь Португал хэл болохоор SENAI-ийн мэргэжилтэнгүүд тэдэнтэй хамтран ажиллахад үр дүнтэй сайн гарна гэдэгт итгэлтэй байна.

Хагас зуун жил үргэлжилж байгаа Япон болон Бразилийн хамтын ажиллагаа нь Бразил улсын хөгжилд том нөлөө үзүүлж байгаагаас гадна цаашлаад Өмнөд Америк, Африкийн зарим Португал хэлээр ярьдаг орнуудад ч мөн үр өгөөжээ өгч эхэлж байна.

ӨМНӨД СУДАНЫ АНХНЫ ОЛИМПЫН ТАМИРЧДЫГ ЖАЙКА ДЭМЖИНЭ

7 сарын 24 өдөр Бүгд Найрамдах Өмнөд Судан улсын тамирчид Бразил улсад зохион байгуулагдах 2016 оны зуны 31 дүгээр олимпид оролцохоор явлаа.



Энэ жил анх удаа Өмнөд Суданы тамирчид олимпын тэмцээнд эрэгтэй 1,500 метр, эмэгтэй 200 метрийн гүйлтийн төрөлд оролцохоор болсон юм. Мөн тус улсын Америкд амьдардаг 3 тамирчин улсаа төлөөлж оролцож байна.

Тус улс урт удаан хугацаанд дайн байлдаан, үймэн самуунтай, улсын эдийн засаг хүнд байдалд байсан учраас олон улсын тэмцээн уралдаанд тамирчдаа оролцуулах боломжгүй байжээ. Энэ оны 7 сард гэхэд нийслэл Жубад Ерөнхийлөгч Сальва Кийрагийн удирдсан засгийн газрын цэргүүд, дэд ерөнхийлөгч Риек Машарын талын босогчдын хооронд 4 хоногийн турш цус асгаруулсан тулаан болж, олон зуун хүн амь насаа алдаж, хотын иргэд олноороо НҮБ-ийн дүрвэгсдийн хуаран руу зугтсан байна.

Энэ хүнд хэцүү цаг үед олимпын тэмцээнд оролцох тамирчдыг дэмжин, тэдний зардлыг даасан ЖАЙКА-ын хамт олонд тус улсын Боловсрол, Залуучууд, Спортын яамны сайд талархлаа илэрхийлээд “Спорт гэдэг бол бүх хүнийг

нэгтгэж чадах их хүчтэй зүйл. Бид улсынхаа эв нэгдэл, энх тайвны төлөө спортыг түлхүү хөгжүүлэх болно. 2020 оны Токиогийн олимпид илүү олон тамирчдаа оролцуулж, медаль авах зорилготой байна. Мөн энэ удаагийн олимпийн тэмцээнд Өмнөд судан улс оролцож, өөрийн орны тугийг олимпийн тавцанд мандуулснаар тус улсын талаар дэлхий даяар мэдэж авах, ирээдүйн залуу үеийнхэнд ч гэсэн илүү гэрэл гэгээтэйгээр амьдралыг харах боломж ирнэ” гэлээ.

Өмнөд судан улс 2011 онд тусгаар тогтнолоо зарлан, дэлхийн хамгийн залуу улс болсон. Тусгаар тогтнолоо зарлахаас өмнө 2005 онд ЖАЙКА-ын төлөөлөгчийн газар Суданд байгуулагдаж, дэд бүтэц, хөдөө аж ахуй, ус сувгийн чиглэлээр дэмжлэг үзүүлж иржээ. Энэ оны 1 сард зохион байгуулагдсан үндэсний спортын анхдугаар тэмцээнийг ЖАЙКА ивээн тэтгэсэн ба цаашид спортын салбарт илүү тусламж дэмлэг үзүүлэхээр ажиллахаар болсон байна.



JAAM ҮЙЛ АЖИЛЛАГАА



“FOLLOW UP” СУРГАЛТ СЕМИНАРЫН ТӨСЛИЙН ШАЛГАРУУЛАЛТЫН ДҮН ГАРЛАА.

ЖАЙКА-ын Монгол дахь төлөөлөгчийн газар болон ЖАЙКА-ын Сургалт төгсөгчдийн холбоо (JAAM) хамтран сургалт төгсөгчдийнхөө сургалтын үр өгөөжийг нэмэгдүүлэх, сургалтын хүрээнд төлөвлөж байсан үйл ажиллагааны биелэлтэнд дэмжлэг үзүүлэх зорилготой “Follow up” сургалт

семинар зохион байгуулах төслийн саналыг та бүхнээс хүлээн авсан билээ.


Идэвхтэй оролцсон нийт гишүүддээ маш их баярлалаа.

Нийт 20 гаруй санал ирснээс дараах 5 салбарт 5 сургалт семинарыг дэмжин, санхүүжүүлэхээр боллоо.

Салбар	Төслийн нэр	Зохион байгуулагч	Зорилго, Үр дүн	Хэрэгжих газар, хамрагдах хүрээ
ЭРҮҮЛ МЭНД	“Сувилахуйн удирдлага”	Н.Цэвэлмаа (2011 онд “Сувилахуйн менежмент” сургалтанд хамрагдсан.)	Дадлагажигч шинэ сувилагчийг хөгжүүлэхэд сургагч багшийн үүрэг, үр чадварыг дээшлүүлэх	Улаанбаатар хот, Нийслэлийн Эрүүл Мэндийн Газрын харьяа 9 дүүргийн 140 сувилагч нарт
БАЙГАЛЬ ОРЧИН	“Японы Токио хотын гамшгийн удирдлагын туршлага, Улаанбаатар хотод нэвтрүүлэх боломж”	Ё.Жаргалсайхан (2016 онд “Газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх, эрсдлийг бууруулах, бэлэн байдлыг хангах үндэсний чадавхийг бэхжүүлэх” сургалтанд хамрагдсан.)	Тус сургалтаар Японы тэргүүний туршлагаас танилцуулж, Улаанбаатар хотын өнөөгийн тогтолцоотой харьцуулан, сайжруулах арга замыг тодорхойлон, хэрэгжүүлэх арга хэмжээг авах, Улаанбаатар хотын гамшгаас хамгаалах чадварыг сайжруулах зорилготой.	Улаанбаатар хот, УАБЗ, БХБЯ, БСШУЯ, ЭМСЯ, СЯ, ОБЕГ, МХЕГ, НЗДТГ, ШУА-ийн ООГХ-ийн 40 ажилчид
ТАТВАР	“Олон улсын татварын тухай үндсэн ойлголт, Монгол улсын давхар татварын гэрээний хэрэгжилт”	Ж.Эрдэнэбүрэн (2014 он “Олон улсын татварын ногдуулалт” /анхан шат/, 2015 он “Олон улсын татварын ногдуулалт” /дунд шат/-ны сургалтанд тус тус хамрагдсан.)	Улсын байцаагч нар үндэстэн дамнасан ажил гүйлгээг таньж мэдэх, Гадаад орны хуулийн этгээдийн Төлөөний газраас татварын ногдуулалт хийх эрх зүйн үндэслэлийг ойлгох, МУ-д хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа 26 оронтой байгуулсан Олон улсын татварын гэрээг ашиглах арга зүйг эзэмшүүлэх	Орхон аймаг, Орхон аймгийн Татварын хэлтсийн улсын байцаагчид 55 хүн 2 өдөр
БОЛОВСРОЛ	“Алтайдаа хамтдаа хөгжье”	С.Алтанзул (2015 онд Залуу удирдагчдыг сургах Математик-Байгалийн ухааны багш нарын сургалтанд хамрагдсан.)	Алтайн багш нарын заах арга зүйн технологи, мэргэжлийн үр чадварыг хөгжүүлэх, чадваржуулахад туршлагаа түгээн дэлгэрүүлэх	Говь-Алтай, Есөнбулаг суманд, Аймгийн 18 сумын 24 сургуулийн сургалтын менежер, байгалийн ухааны 48 багш нар
ХӨДӨӨ АЖ АХУЙ	“Хүнсний аюулгүй байдал: Үр тариа, малын тэжээл дэхь микотоксины бохирдол, нөлөөлөх хүчин зүйлс эрсдэлийн үнэлгээ, микотоксин илрүүлэх шинжилгээний аргууд”	Г.Батзул (2015 онд Монгол улсын хүнсний аюулгүй байдлыг хамгаалахад лабораторийн шинжилгээний чадавхийг сайжруулах, чанарын хяналт, эрсдэлийн үнэлгээг бэхжүүлэх нь сургалтанд хамрагдсан.)	Япон улсад JICA-ийн шугамаар хамрагдсан сургалтаас эзэмшсэн мэдлэг, туршлагаа бусдад түгээн дэлгэрүүлэх тэр дундаа хүнсний аюулгүй байдлын чухал үзүүлэлт болох- микотоксины бохирдол, нөлөөлөх хүчин зүйлс, эрсдэлийн үнэлгээний тухай ерөнхий ойлголт болон микотоксин илрүүлэх лабораторийн шинжилгээний аргыг эзэмшүүлэх зорилготой.	Улаанбаатар хот, Мэргэжлийн хяналтын лабораторийн шинжээчид /4-6 хүн/, үр тариа, малын тэжээл тарьж ургуулдаг, үйлдвэрлэдэг, түүхий эд болгон хэрэглэдэг хувийн хэвшлийн хүнс, малын тэжээлийн үйлдвэр, аж ахуйн нэгжүүдийн лабораторийн 50 орчим шинжээч, мэргэжилтнүүд



ЯПОНЫ ХӨГЖЛИЙН ТУРШЛАГААС



Япон улс нь орчин үеийн нийгэм, эдийн засгийн аж үйлдвэржилтийг бүрдүүлж чадсан хамгийн анхны Азийн буюу барууны бус орон байлаа. 140 гаруй жилийн өмнө эхэлсэн энэхүү үйл явцын гол цөм нь “олж аваад өөртөө тохируулах” гэсэн ойлголт байсан бөгөөд маш олон төрлийн мэдлэг ур чадварыг хөгжсөн орнуудаас оруулж ирэн, дотоодын мэдлэг ур чадвар,

санаачлагатай хослуулан өөртөө тохируулан сайжруулж иржээ. Эцэстээ тэдгээрийг Японы нийгэмд дотоодын хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрийн болгож авсан байна.

Япон улсыг өнөөгийн хөгжилд нь хүргэсэн инженерийн технологиос авахуулаад үйлдвэрлэлийн удирдлагын аргачлал хүртэлх олон ноу-хау нь энэхүү “олж аваад өөртөө

тохируулах” үйл явцаас үүдэлтэй бөгөөд мэдээж энэ бүхэн нь маш олон алдаа онооны үр дүнд бий болсон амжилтын түүхтэй холбоотой байдаг. Эдгээр амжилт болон алдааны туршлагуудыг аль алинаас судлах нь бидний түнш орнуудын хувьд өнөөгийн хөгжиж буй үйл явцад нь тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэхэд нь тустай байх болно гэж үздэг.

Гэхдээ түнш орнуудтайгаа Японы хөгжлийн замналын туршлагыг бүхэлд нь хуваалцана гэдэг илүү төвөгтэй хэцүү зүйл юм. Энэ хүндрэл нь тодорхой хэмжээгээр үгээр юм уу тоогоор илэрхийлж тайлбарлах боломжгүй “далд мэдлэг”-ийн талаар тайлбарлахтай холбоотой байдаг.

Үүнээс гадна Японы нийгэм соёлын систем нь барууны аж үйлдвэржсэн орнуудаас маш их ялгаатай байдаг тул ихэнх түншлэгч орнуудын хувьд төдийлөн танил биш зүйлс оршсоор байна. Энгийнээр хэлэхэд Японд ирснээрээ иймэрхүү соёлын ялгааг багасгах боломжтой байж болох юм.





ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДАЛ ГЭЖ ЮУ ВЭ?

ХООЛ БЭЛТГЭХ, БОЛОВСРУУЛАХАД АНХААРАХ ЗҮЙЛС

Түүхий ба болгосон хүнсийг холилдуулахгүйн тулд дараах зүйлсийг анхаарна.

- Болсон ба түүхий бүтээгдэхүүн тус бүрт зориулсан гампанз болон бусад хэрэгслийг тусгайлан бэлтгэх
- Түүхий хүнсийг боловсруулахад хэрэглэсэн гал тогооны хэрэгслийг угаалгын бодистой халуун усаар угааж ариутгах
- Мах, загас, өндөг, сүү зэрэг амьтны гаралтай хүнсийг гүйцэд сайн болгож хэрэглэх

ХООЛ БЭЛТГЭХ ҮЕИЙН ХУВИЙН АРИУН ЦЭВЭР

- Хоол бэлтгэхээс өмнө гараа сайн угаана.
- Мах, загас, тахиа, өндөг зэрэг түүхий хүнсийн бүтээгдэхүүн бэлтгэсний дараа бусад хүнсийн бүтээгдэхүүнд хүрэхээс өмнө гараа угаана.

- Хүний гарт байгаа эмгэг төрүүлэгчид хоолонд орвол хүнийг өвчлүүлж, улмаар үхэлд хүргэх аюултай.
- Гараа тогтмол угааж цэвэр байлгаснаар өөрсдийгөө болон хэрэглэгчдийг халдвараас сэргийлнэ.

ЦЭВЭРЛЭГЭЭ, АРИУТГАЛ

Хүнс хоолтой хүрэлцдэг бүх гадаргууг хэрэглэсний дараа тогтмол цэвэрлэж ариутгана. Цэвэрлэгээний сайн чанарын бодис болон угаах багаж, хэрэгсэлтэй байх шаардлагатай.

Ариутгалын зарчим:

- Хэт улаан туяагаар ариутгах: Багаж, хэрэгсэл, төхөөрөмжийг тодорхой хугацаанд хэт улаан туяагаар ариутгадаг.
- Химийн бодисоор ариутгах: Бичил биетний эсийн бодисын солилцоог саатуулах зорилгоор хэрэглэнэ.
- Өндөр температурт ариутгах: Температур нь бичил биетнийг устгахад хангалттай байх шаардлагатай.

